



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 02-р адэр

Дугаар 67

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Сайнцагаан сумын Тавдугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 15,684,171 /арван таван сая зургаан зуун наян дөрвөн мянга нэг зуун далан нэг/ төгрөгийн балансын үнэтэй, 497,911 /дөрвөн зуун ерэн долоон мянга есөн зуун арван нэг/ төгрөгийн элэгдэл бүхий цэвэр бохир усны шугамыг хавсралтын дагуу аймгийн “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Тавдугаар цэцэрлэгийн эрхлэгч Л.Дэлгэрмаа, “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 09-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав:.. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА

C.СУХБААТАР

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 Тэргүүлэгчдийн 2019 оны 07 дүгээр сарын
 02-дөдрийн 07 тогтоолын нэгдүгээр хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Too хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хүримтлагдсан элэгдэл	Үддэгдэл өртөг
1	Цэвэр усны шугам	2009/01/01	диаметр	124.15	88,816.87	11,026,614.41	350,053.34	10,676,561.07
2	Бохир усны шугам	2009/01/01	диаметр	57.0	87,711.52	4,657,556.64	147,858.00	4,509,698.64

							15,684,171.05 /арван таван сая зураган зуун наян дөрвөн мянга нэг зуун далан нэгэн төгрөг/	497,911.34 /дөрвөн зуун ерэн долоон мянга есэн зуун арван нэгэн төгрөг/ зуун тавин есөн төгрөг/
--	--	--	--	--	--	--	---	--